

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журмын хавсралт-1

### Компанийн төслийн мэдээлэл

<b>Байгууллагын нэр</b>	ҮМТ-гийн дээд хэсэгт тухайн компаний албан ёсны нэрийг бичнэ. Нэрийг бичихдээ товчлохгүй байвал зохино. Жишээ нь: Магнай Трейд ХХК-ийг МТ гэж товчилж болохгүй.
(Регистрийн дугаар)	Байгууллагын регистрийн дугаар
(Улсын бүртгэлийн дугаар)	Байгууллагын Улсын бүртгэлийн дугаар
(Байгуулагдсан огноо)	Тухайн аж ахуйн нэгж байгууллагын үүсгэн байгуулагдсан огноо эсвэл тухайн хувь хүний бизнес хийж эхэлсэн огноо.
(Эзэмшигчид)	Хамгийн том хувьцаа эзэмшигчдийг эзэмшиж байгаа хувьцааны хувь хэмжээгээр ихээх нь бага руу нь дэс дараалуулан бичнэ. Мөн эзэмшиж байгаа хувьцааны хувь хэмжээг бичнэ.
<b>Удирдлагын Нэр</b>	<b>Захирлуудын Зөвлөлийн болон удирдлагын гишүүдийн нэр</b>
(Албан тушаал, ур чадвар, мэргэжил, туршлага )	Албан тушаал
(Хэдийнээс)	Уг албан тушаалд хэдийнээс эхлэн ажилласан
(Төрсөн огноо)	Төрсөн он, сар, өдөр
(регистрийн дугаар)	Захирлын регистрийн дугаар
(иргэний үнэмлэхийн дугаар)	Захирлын иргэний үнэмлэхийн дугаар
Ажиллах хүчин	Тухайн компани нийт хэдэн ажиллагсадтай, үүнээс хэд нь нарийн мэргэжлийн болох, бизнесийн циклтэй холбогдон ачаалал их үед үндсэн ажиллагсадаас гадна түр хугацаагаар буюу гэрээгээр өөр ажиллагсадыг ажиллуулдаг эсэх талаар бичих.
Collateral (Барьцаа хөрөнгө)	Зээлийн барьцаа хөрөнгийн нэр төрөл, чанарын талаар товч дурдана. Мэдээлэл тодорхой биш тохиолдолд N/A гэж бичнэ
Үйл ажиллагаа/Үйлдвэрлэл болон түгээлт	Компанийн эрхэлдэг үндсэн үйл ажиллагаа /Зээлийн шинжилгээний тайланд –тухайн зээлийн өргөдөлтэй холбоотой бизнесийн талаар бичнэ./ бизнесийн талаар бичнэ. Мөн үйлдвэрлэл, гол нэр төрлийн бүтээгдэхүүн, түгээлтийн сүлжээний хэмжээ, байрлал, төрлийн талаар дурдана. Тухайн зээлдэгч өөрийн бүтээгдэхүүнээ ямар сувгаар (өөрийн сүлжээгээр, бөөнийн сүлжээгээр эсвэл худалдааны төлөөлөгчөөр дамжуулан гэх мэт) борлуулдгийг бичнэ.
Худалдааны нэр хүнд	Зээлдэгч болон түүний бүтээгдэхүүний нэр хүнд худалдан авагчдын дунд ямар вэ, энэ нь бүтээгдэхүүнээ зарах, түгээх нөхцөлд хэрхэн тусгалаа олсныг бичих Тухайн компани нь бэлтгэн нийлүүлэгчдийнхээ дунд ямар байр суурь эзэлдэг, энэ нь зээлдэгчийн худалдан авах гэрээний нөхцөлд хэрхэн нөлөөлдгийг бичнэ.
Гол бэлтгэн нийлүүлэгчид болон худалдан авах нөхцөл	Гол бэлтгэн нийлүүлэгчид, тэдгээрийн байршил, төвлөрөл /гол түүхий эдийн хувьд маш цөөхөн тооны бэлтгэн нийлүүлэгчээс хамааралтай байх/, нэгдэл (бэлтгэн нийлүүлэгчдийн аль нэг нь тухайн компанитай холбоотой эсэх)-ийн талаар болон гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээ худалдан авдаг нөхцлийн талаар бичнэ. Ямар ямар нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэдэн хувь нь урьдчилгаа төлбөрөөр, хэдэн хувь дараа төлбөрөөр хийгддэг болон аккредитив ашигладаг эсэх, ашигладаг бол аккредитивийн нөхцөл гэх мэт бэлтгэн нийлүүлэгч, худалдан авалтын нөхцлийн талаархи бүх мэдээллийг хамруулна.
(Гол харилцагчид/худалдан авагч, борлуулалтын нөхцөл)	Гол худалдан авагчид, тэдгээрийн байршил, төвлөрөл /цөөхөн тооны худалдан авагчаас хамааралтай байх/, нэгдэл (худалдан авагчдын аль нэг нь тухайн компанитай холбоотой эсэх)-ийн талаар болон борлуулалтын нөхцлийн талаар дэлгэрэнгүй бичих.
Зээлийн түүх	Энэ хэсэгт зээлдэгчийн сангаас авч байсан зээлийн түүхийг бичнэ. <ul style="list-style-type: none"> <li>• Зээл олгогдсон огноо</li> <li>• Зээлийн дүн</li> <li>• Зээлийн хүү</li> <li>• Төлсөн хүүгийн хэмжээ</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Зээлийн хугацаа</li> <li>• Зээл төлөгдсөн огноо</li> </ul>
Зах Зээл	<p>Энэ хэсэгт дараах мэдээллийг оруулсан байх хэрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зээлдэгчийн зах зээлийн өсөлт хөгжилт, цикль/насжилт өнгөрсөн хугацаанд ямар байдалтай байсан, ирээдүйд ямар байх талаар хийсэн прогноз;</li> <li>• Ижил хэмжээний компаниудтай харьцуулсан шинжилгээ: Зах зээл дээр эзлэх хувь хэмжээ, нэр хүнд, сул ба давуу тал, боломжийн талаар судалж дүгнэн бичих.</li> </ul>
Зээл эргүүлэн төлөх эх үүсвэр	<p>Энэ хэсэг нь дараах асуудлыг хамарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүжүүлэх гэж буй төслийн талаар тодорхой тайлбарлана. Тухайлбал: санхүүжилттэй холбоотой гэрээ хэлцэлд тусгагдсан гол нөхцөлүүийн талаар дурдана.</li> <li>• Төслийн санхүүжилт болон томоохон зээлүүд дээр банкны зээлээс гадна бусад эх үүсвэрийг (хувь нийлүүлэгчдээс оруулах хөрөнгө, хувьцаа гаргаснаар орж ирсэн мөнгө, бусад банкны зээл гэх мэт) хаанаас гаргах талаар;</li> <li>• Зээл эргэн төлөх эх үүсвэрүүдийн талаар;</li> <li>• Зээлийн дүн батлагдсаны дараа дахин шинээр зээл нэмж батлуулах хүсэлт гарч болох бол энэ талаар таамаглал хийх;</li> <li>• Батлагдсан зээлийн нөхцөл болон заавал биелүүлэх нөхцлийг зээлдэгч мөрдөж чадаагүй тохиолдолд яагаад мөрдөж чадаагүй вэ гэдгийг тайлбарлана.</li> </ul>
Орлогын талаархи мэдээлэл	<p>Том дүнтэй огцом өөрчлөлт дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Борлуулалтын орлого, түүний хэдэн хувь нь ямар хугацаатай зээлээр хэдэн хувь нь бэлнээр хийгддэг болох</li> <li>• Нийт ашгийн түвшин (үнийн бодлого, бүтээгдэхүүний төрлүүд, өрсөлдөх чадвар, түүхий эдийн үнийн ойрхон өөрчлөлтөөс хамааралтай эсэх);</li> <li>• Үйл ажиллагааны болон цэвэр ашгийн түвшин (үр ашиг);</li> <li>• Ашигт ажиллагааны түвшний шинж чанар (тогтмол биш онцгой шинж чанартай орлогуудаас хамааралтай байдаг эсэх);</li> <li>• Ноогдол ашиг хуваарилалтын бодлого.</li> </ul>
Эрсдлийн шинжилгээ	<p>Тухайн зээлийн хүсэлт, баримт бичгийг бүрэн судалж өөрийн дүгнэлтийг өгсөний дараа зээлд нөлөөлж болзошгүй эрсдлийн талаар болон учирч болзошгүй эрсдлээс гарах арга зам, зээл төлөх чадваргүй болсон нөхцөлд авах арга хэмжээний талаар саналаа оруулна.</p>
с) Гүйцэтгэлийн эрсдэл	<p>Энд тухайн санхүүжүүлэх гэж буй бизнесийг хэрэгжүүлэхэд үүсч болох дараах эрсдлүүдийн нөлөөллийг тооцож түүнээс гарах арга замын талаар бичих.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зардлын шинжилгээ;</li> <li>• Удирдлага (удирдах ур чадвар, мэдлэг, туршлага);</li> <li>• Үйлдвэрлэл (гүйцэтгэл, чанар/нэхэмжлэл).</li> <li>• Нийлүүлэлтийн нөхцөл;</li> <li>• Үнэ (огцом өөрчлөлт, эрсдлээс хамгаалсан стратеги);</li> <li>• Хуулийн баримтууд.</li> </ul>
Харилцагч банкны талаархи мэдээлэл	<p>Нийт хэдэн банктай ямар ямар чиглэлээр хамтран ажилладаг, зээлдэгчийн болон холбогдох компаниудын (толгой компани гэх мэт) манай банкаар үйлчлүүлдэг үйлчилгээнүүдийн талаар /жишээ нь: харилцах болон зээлийн дансдын/ тайлбарыг өгнө. Харин эдгээрийн хэмжээ болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг ҮМТ тусгана.</p>
Дүгнэлт	<p>Хийсэн дүгнэлт, ямар нөхцөлтэйгээр зээлийг батлуулах санал оруулж байгаагаа тодорхой бичнэ. Өмнө батласан зээлийн нөхцлийг биелүүлээгүй, чөлөөлүүлэх санал оруулах шаардлагатай бол энэ хэсэгт тэмдэглэнэ.</p>